

ТАНИЛЦУУЛГА

*Тэтгэвэр тогтоолгох үндэсний
ажил, мэргэжлийн жишиг цалин батлах
тухай*

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан ажил, мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлж болно” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/136 дугаар тушаалаар ажил мэргэжлийн жишиг цалингийн хэмжээг шинэчлэн баталж, мөрдөж байна. Энэхүү тушаал нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5468 дугаарт бүртгэлтэй болно.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг тус тус хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 20 дугаар зүйлийн 20.6-д “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл боловсруулав.

Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг Үндэсний ажил, мэргэжлийн ангилал тодорхойлолтын 10 бүлгээр тодорхойлсон.

ҮАМАТ-ын 2 кодтой “Мэргэжилтэн” бүлгийн “Багшлах мэргэжилтэн” дэд бүлэгт суурь, бүрэн дунд боловсролын багш, бага болон сургуулийн өмнөх боловсролын багш, их дээд сургуулийн дээд боловсролын багш, техник мэргэжлийн боловсролын багш, бусад багшлах мэргэжилтнүүд хамрагдаж байна.

Мөн энэ бүлгийн “Эрүүл мэндийн мэргэжилтэн” дэд бүлэгт хүний их эмч, сувилахуй, эх барихуйн мэргэжилтэн, уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн,

яаралтай тусламжийн эмч, ажилтан, эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, малын эмч зэрэг ажил, мэргэжил хамаарч байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын хавсралтаар батлах жишиг цалингийн “Мэргэжилтэн” бүлэгт хамаарах ажил мэргэжлээр ажиллаж байсан даатгуулагчийн жишиг цалингийн хэмжээг 1990 он ба түүнээс өмнөх хугацаанд 650 төгрөг, 1991 онд 1300 төгрөг, 1992 он 2250 төгрөг, 1993 онд 5700 төгрөг, 1994 онд 10200 төгрөг байхаар тус тус тооцоолов.

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал тодорхойлолтын дагуу 10 бүлгээр ангилсан тул тухайн даатгуулагчийн эрхэлж байсан ажил, мэргэжил нь таарахгүй эсхүл олдохгүй байх боломжгүй юм.

Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил мэргэжлийн жишиг цалингийн хэмжээг шинэчлэн баталснаар Нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт зардал гарахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ